



**BPN**   
Business Professionals Network

Монголын үйлдвэрлэлийн хөгжлийн төлөө



**BPN Монгол**

## BPN Монгол салбарын өнөөдөр ба ирээдүй

Миний бие Рене Лухсингер 2023 оны 6-р сард BPN Монгол салбарыг удирдах хүндтэй үүргийг хүлээн авсан билээ.

Юуны түрүүн миний сэтгэлийг хөдөлгөсөн зүйл бол манай багийн хичээл зүтгэл, тууштай байдал байлаа. Хүн бүр өөрийн тавьсан зорилгодоо хүрэх гэж хичээнгүйлэн ажиллах бөгөөд ингэснээр багийн зорилго амжилттай биелдэг. Зөвхөн уйгагүй зүтгэл, багийн ажиллагааны ачаар зорилгодоо хүрэх боломжтой болдог.



BPN Монгол  
салбарын захирал:  
**Рене Лухсингер**

Энэ дашрамд багийнхаа гишүүн бүрд талархал илэрхийлье.

Мөн BPN-ийн хөтөлбөрийн онцлог давуу талуудын нэг бол бусдад танигдсан сургалт, түүний өндөр чанар юм. Сургалтад хамрагдсан бизнес эрхлэгчдийн эерэг сэтгэгдлүүд биднийг урам зоригоор тэтгэж, цаашдын хөгжил дэвшлийн төлөө тасралтгүй ажиллахыг сануулж байна.

Түүнчлэн энэ жилийн нэг онцлох үйл явдал бол Швейцар улсад хийсэн туршлага судлах бизнес аялал байлаа. Энэ аялалд BPN-ийн хөтөлбөрийн оролцогч 13 бизнес эрхлэгч хамрагдан бизнесийн туршлага судалснаас гадна өөрсдийн санал бодлоо солилцох, харилцаа холбоо тогтоох зэрэг цаашдын ирээдүйгээ өөрөөр олж харах боломжийг олгосон аялал болсон юм.

Мөн бид шинэ чадварлаг ажилтнуудаар баг хамт олноо нэмэгдүүлснээс гадна ажилтануудынхаа тав тухтай ажиллах нөхцөлийг сайжруулан оффисоо шинэчилж ая тухтай орчинг бүрдүүллээ.

Ирж буй 2024 оноо бид том зорилго тавин, итгэл дүүрэн, урам зоригтойгоор угтаж байна. Бидний зохион байгуулдаг удирдлагын сургалтуудын төлөвлөгөө хэдийн дүүрсэн бөгөөд хөтөлбөрийн оролцогч бизнес эрхлэгчдээ цаашид ч өөрсдийн мэдлэг, туршлагаараа дэмжин ажиллаж тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг санал болгон ажиллах болно.

2024 оныг амжилт бүтээлээр дүүрэн өнгөрүүлж, ирээдүйгээ та бүхэнтэй хамтдаа бүтээнэ гэсэн итгэл дүүрэн байна.

Өнөөг хүртэл бидний амжилтыг бүтээхэд хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст маш их баярлахын зэрэгцээ цаашдын ажилд нь өндөр амжилтыг хүсье!



## ВРН таныг бизнесээ хөгжүүлж, өргөжүүлэхэд туслах түнш байгууллага.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд манай баг хамт олны тууштай, илэн далангүй нээлттэй, зогсолтгүй хамтын ажиллагааны үр дүнд өнөөдрийн ВРН оршин тогтнож байгаа билээ. Үүнд манай баг хамт олон асар их үүргийг гүйцэтгэсэн. Бид баг дотроо нөхөрсөг, шударга хамтран ажиллаад зогсохгүй ВРН-ийн хөтөлбөрийн оролцогчид болон хамтран ажиллагч байгууллагуудтайгаа мөн л дээрх “**ҮНЭ ЦЭНЭ**”-д тулгуурлан ажиллаж байна.

Тиймээс бидний бизнес түншүүд, хамтран ажиллагч байгууллагууд бидэнтэй урт хугацаанд, тогтвортой хамтран ажиллаж, бид Монгол улсынхаа хөгжлийн түүхийн хуудсыг хамтдаа бичилцэж байна.

Бид алсын хараа, зорилгуудынхаа хүрээнд 2023 онд ХААН Банк болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоотой (ТоС) хамтран нэмүү өртөг шингээн үйлдвэрлэл эрхэлж буй бизнес эрхлэгчдийнхээ удирдлагын чадварыг ахисан түвшинд хүргэх, мөн санхүүжих чадамжийг нь сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ.

Бизнес эрхлэгчдийн санхүүжих чадамжийг зөвхөн зээлжих чадвараар дүгнэх нь учир дутагдалтай байдаг тул өөрсдийгөө бүрэн санхүүжүүлэх чадвар руу чиглүүлж, түүнд тохирох арга барил болон Tool-ийг санал болгосон билээ. Ингэснээр тэд дор бүрнээ үр ашиг, өгөөж бүхий өөрсдийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж түүнийхээ дагуу санхүүгээ зөв удирдах дадалд суралцсан.

Аливаа шийдвэрийг гаргахад бизнес эрхлэгчид ганцаардаж, тулгамдаж өөртөө итгэлтгүй байх тохиолдол элбэг байдаг. Тиймээс ч өнөөгийн бизнесийн ертөнцөд “Хамтын ажиллагаа” нэн чухал зүйл болж байна. Энэ ч утгаараа ВРН хамтран ажиллагч байгууллагууд болон бизнес эрхлэгчдэдээ бизнес көучинг санал болгож тэднийг зөв шийдэлд хүрэхэд нь түлхэц өгч чиглүүлдэг.

Цаашдаа ч бид өнөөгийн болон ирээдүйн удирдлагууддаа манлайллын сургалтуудыг түлхүү санал болгож, “Leadership Coaching”-өөр чиглүүлж, хүнд хэцүү хямралын энэ үеийг даван туулахад нь хамтдаа байж, өөрсдийн хувь нэмрийг оруулж ажиллана.



ВРН-ийн  
хөтөлбөрийн  
удирдагч,  
бизнес көүч  
**О. Эрдэнэсүрэн**



## Бизнес зөвлөгөө болон удирдлагын көүчинг үйлчилгээний тухай



BPN Монгол – жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн удирдлагын зөвлөгөө болон көүчинг үйлчилгээг санал болгож байна.

Бизнесийн ертөнцөд зөвлөгөө болон көүчинг үйлчилгээ нь зайлшгүй байх тогтсон зүйл бөгөөд ЖДҮ эрхлэгчдэд нэн чухал ач холбогдолтой. Энэ үйлчилгээ нь бизнесийн хөгжил, удирдлагыг сайжруулахад чиглэсэн нарийн арга барил юм.

### ЖДҮ эрхлэгчдэд зориулсан көүчинг үйлчилгээ

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан көүчинг үйлчилгээ нь туршлагатай көүч тусгайлсан заавраар тэднийг чиглүүлэн, дэмжлэг үзүүлдэг. Энэ нь бизнес эрхлэгчид, менежерүүдэд ур чадвараа хөгжүүлэх, саад бэрхшээлийг даван туулах, зорилгодоо хүрэхэд тусалдаг. Көүч нь тухайн хүмүүсийн хувийн болон мэргэжлийн ахиц, хөгжилд анхаарч ажилладаг бөгөөд манлайллын ур чадварыг сайжруулах, зөрчилдөөнийг зөвөөр зохицуулах, стресс, тодорхойгүй байдлыг удирдах зэрэг сэдвүүдээр чиглүүлэг өгдөг.

### ЖДҮ эрхлэгчдэд зориулсан бизнесийн зөвлөгөө

Зөвлөх үйлчилгээ нь бизнесийн төрөл бүрийн салбаруудад тохирсон мэргэшсэн, туршлага бүхий мэдлэгээр хангах үйлчилгээ юм. Зөвлөх үйлчилгээ нь дийлэнхдээ тодорхой төсөл эсвэл асуудал дээр ашиглагддаг. Зөвлөхүүд компанийн үйл явцад дүн шинжилгээ хийж, сул талуудыг тодорхойлон, сайжруулах тодорхой зөвлөмжийг санал болгодог. Энэ нь санхүүгийн төлөвлөлт, маркетингийн стратеги, байгууллагын хөгжил мөн бизнесийн бусад асуудлуудыг хамарч болно.

### Амжилтын түүх

Жижиг, дунд үйлдвэрлэлийн олон салбар бизнесийн зөвлөгөө, көүчинг үйлчилгээний ашиг тусыг хүртэж чаддаг. Эдгээр үйлчилгээ нь компаниудад өрсөлдөх чадвараа бэхжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, урт хугацааны өсөлтийн зорилгодоо хүрэхэд тусалдаг. Амжилттай хэрэгжүүлсэн жишээнүүд нь бизнесийн гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалттай аргачлалууд хэрхэн үр дүнгээ өгдгийг харуулдаг билээ.





## Бизнес зөвлөгөө болон удирдлагын көүчинг үйлчилгээ

Намайг Онон овогтой Отгонжаргал гэдэг. Би Санжайн хишиг ХХК компанийн үүсгэн байгуулагч бөгөөд одоогоор гүйцэтгэх захирлын албан тушаалд ажиллаж байна. Манай компани 2017 онд үүсгэн байгуулагдсан. 2018 онд МХАУТ-аас “Оны шилдэг гарааны бизнес” эрхлэгч шагнал хүртсэн бөгөөд хэрэглэгчдийн эерэг сэтгэгдлүүд, бүтээгдэхүүний үр дүн зэрэг нь бидэнд илүү эрч хүчтэй ажиллах урам зориг хайрлан ажилласаар өдгөө 7 дахь жилтэйгээ золгож байна.

2023 оны 3-р сараас BPN байгууллагатай танилцан, тэдний санал болгодог сургалт зөвлөгөөнд хамрагдаж, BPN-ийн үйл ажиллагаа таалагдсан учир 6 сард хамтран ажиллах гэрээг байгуулсан билээ.

Гэрээ байгуулан хамтран ажиллаж эхэлснээс хойш 3-4 сар болж байгаа бөгөөд энэ хугацаанд олон улсын зөвлөх Рене Лүхсингер манай үйл ажиллагаатай танилцан мэргэжлийн түвшинд хэрхэн бизнес хийх тал дээр өөрийн үнэт зөвлөгөөг харамгүй хэлж өгсөн.

Мөн бид 3 төрлийн сургалтад хамрагдан өөрсдийн үйл ажиллагааг шинэчлэх, улам сайжруулах тал дээр ажилласаар байна.

BPN-ийн гол үйлчилгээний нэг болох бизнес көүчинг маш сонирхолтой болдог. Бидний хүссэн, шаардлагатай сэдэв дээр биднээс асуулт асууж ойлгуулах замаар көүчинг эхэлнэ. Үүний дараа уг асуудлыг илүү тодорхой, нарийн, цогцоор нь харахад туслах ажлыг хамтдаа хийдэг. Харин ойлгосноо илүү сайжруулах, хэрэгжүүлэх нь тухайн бизнес эрхлэгчийн даалгавар болдог.

Миний хувьд бизнесийн нэг чухал зорилт болох алсын харааг тодорхойлох көүчинг үйлчилгээ авсандаа сэтгэл маш хангалуун байна.



Санжайн хишиг ХХК  
-ийн гүйцэтгэх  
захирал  
**О.Отгонжаргал**





Өмнө нь алсын хараагаа би зөвхөн өөрийн үзэл бодлыг тусган гаргасан байсан бол көүчинг уулзалтын дараа зөвхөн миний бус, манай байгууллагын гол цөм болсон хамт олныхоо итгэл үнэмшил, үзэл бодлыг тусгаж, хэнд, юуг, юуны төлөө гэх мэт асуултаар алсын хараагаа тодорхойлох нь илүү оновчтой, төгөлдөр болдог гэдгийг ойлгон шинэчлэн сайжруулсан.

Цаашлаад бид маркетинг, санхүү бүртгэлээ сайжруулах тал дээр илүү төвлөрч дараа дараагийн көүчинг үйлчилгээг авахаар төлөвлөж байна.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж оюуны хөрөнгө оруулалт хийж байгаад нь олон олон гарааны болон жижиг дунд бизнес эрхлэгчдийнхээ өмнөөс маш их талархаж байгаагаа энэ дашрамд дурдахад таатай байна.





## ВРN-ийн Бизнес Академи

Манай “Бизнес Академи” нь бизнес эрхлэгчдэд Швейцарын системчилсэн арга зүйгээр, тухайн орны томоохон компаниудын бодит жишээ, туршлагууд дээр суурилсан бизнесийн удирдлагын суурь мэдлэг олгох сургалтуудыг санал болгодог.

Энэ жил бид өмнөх жилүүдээс харьцангуй олон сургалтуудыг зохион байгуулан тун үр бүтээлтэй өндөрлөж байна.



ВРN-ийн  
сургалт хариуцсан  
ажилтан:  
**Д.Хүслэн**



Эдгээрийг тодруулбал компанийн захирал, удирдлагуудад чиглэсэн ВРN-ийн үндсэн 4 сургалтууд болох “Бизнесийн удирдлага” сургалтыг 2 удаа, “Санхүүгийн менежмент”, “Маркетинг” болон “Хамт олноо удирдах” гэсэн сургалтуудыг тус тус зохион байгуулсан. Мөн бид үндсэн сургалтуудаас гадна хөтөлбөрийн оролцогчид, бизнес эрхлэгчдэдээ зориулан нэмэлт сургалтуудыг санал болгодог.

2023 оны хувьд хэд хэдэн шинэ сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд эдгээрээс хамгийн эрэлт хэрэгцээ бүхий ВРN-ийн Швейцар эксперт Маркус Крамерийн “Брендинг & Илүү их хэрэглэгч олох нь”, мөн хатагтай Клаудиа Габлерийн “Бизнесийн эерэг харилцаа”, сэдэвт сургалтуудыг онцлох нь зүйтэй.



Мөн түүнчлэн „Бизнесийн гэрээ хэлэлцээр“ сургалтыг эрх зүйн чиглэлээр Швейцар болон олон улсын хэмжээний туршлагатай, салбарын эксперт, хуульч Штефан Хофер удирдан явуулсан бөгөөд гадаад худалдааны нөхцөлүүд, гэрээний зөв бүтэц, хөрөнгө оруулалтын болон Франчайз гэрээнүүдийн загваруудыг танилцуулах зэрэг бизнес эрхлэгчдэд тулгамддаг сэдвүүдийг хамарсан юм.



Манай нийгмийн тулгамдсан асуудлуудын нэг болох “ЗӨВ ХАНДЛАГА” -тай байх талаар хөтөлбөрийн оролцогчдынхоо ажилтнуудад тусгайлан “Хандлагын менежмент”, “Байгууллагын ёс зүй” сургалтуудыг ажилтнуудаа сэдэлжүүлэх, урам зоригжуулах зорилго дор мөн байгууллагынхаа алсын харааг хамтдаа тодорхойлж компанийнхаа хөгжлийн түүчээ болох боломжийг олгох “Байгууллагын алсын хараа” гэсэн сургалтыг амжилттай зохион байгууллаа.



*“Боловсрол эзэмшихийн зорилго нь мэдэхэд бус хэрэгжүүлэхэд оршино” гэдэг.*



Ирэх 2024 онд бид Швейцар экспертүүдээс гадна дотоодын чадварлаг сургагч багш нартай хамтран бизнес эрхлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцэхүйц, цаг үеэ мэдэрсэн сургалтуудыг санал болгохоос гадна байгууллага, хамт олны хүсэлтийн дагуух сэдэвт сургалтуудыг олноор хийх төлөвлөгөөтэй байна.



Эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй эрхэм баялаг бүтээгч та бүхэнтэй хамтран ажиллахдаа BPN-ийн зүгээс үргэлж таатай байх болно.





## Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг

BPN-ийн үе үеийн хөтөлбөрийн оролцогчдын нэгдэл болох BPN-ийн бизнес эрхлэгчдийн нийгэмлэг маань 2023 онд төлөвлөгөөний дагуу дараах үйл ажиллагаануудыг нийт нийгэмлэгийн гишүүддээ зориулан зохион байгууллаа.

Үүнд:

- Дотоодын үйлдвэртэй танилцах уулзалт: Чиглэл ХХК,
- Швейцар технологийн зөвлөгөө: Цайдам Трейд ХХК, Алтан Элч ХХК, Дүүрэн Фүүд ХХК, Эм Эс Гармент ХХК, Нар Та ХХК,
- BPN Нээлттэй хаалганы өдөрлөг – Нэтворкинг эвэнт,
- Швейцарын бизнес аялал
- Бүх гишүүдийн жилийн эцсийн уулзалт – Нэтворкинг эвэнт.

Эдгээрээс онцлоход Швейцарын туршлага судлах бизнес аялалд энэ жил 13 бизнес эрхлэгчид хамрагдсан. Тус аяллын хүрээнд Монголын бизнес эрхлэгчид дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Швейцарын томоохон үйлдвэрүүд болох

- Gebrüder Spiegel AG
- Gate Gourmet
- Victorinox
- Obrist interior AG
- Bühler Group
- Kybun World
- Plaston AG

зэрэг 7 үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцан, тэдний зуу зуун жил бизнесийн амжилтаа хадгалахад нөлөөлж буй олон арван бизнесийн удирдлагын ур чадвар, арга техник, туршлагыг судаллаа.

Бид 2024 онд нийгэмлэгийн үйл ажиллагааг илүү өргөжүүлж зөвхөн нийгэмлэгийн гишүүддээ зориулсан бизнесийн удирдлагын цаг үеийн шинэлэг илтгэлүүдийг цуврал болгон хүргэхээр төлөвлөж байна. Үүний зэрэгцээ уламжлал болсон Швейцарын туршлага судлах бизнес аялал, дотоодын үйлдвэртэй танилцах уулзалтууд, Нэтворкинг эвэнтүүдээ тогтмол зохион байгуулах тул хөтөлбөрийн оролцогч бизнес эрхлэгч та бүхнийг манай нийгэмлэгт хамрагдахыг урьж байна.



BPN-ийн  
Бизнес кeүч:  
**С.Цэндсүрэн**





**ВРN нийгэмлэгийн Швейцар улс руу туршлага судлах бизнес аялалд хамрагдсан "Дэгжин Гоо" брэндийн үүсгэн байгуулагч Т.Рэнцэнхандын аяллын талаарх сэтгэгдлийг хүргэж байна.**

Намайг Түвшинбаяр овогтой Рэнцэнханд гэдэг.

"Түвшин Тулга Трэйд" ХХК-ийн "Дэгжин Гоо" брэндийн үүсгэн байгуулагч. Бид монгол хонины ноосоор 100% гар аргаар эсгий гутал үйлдвэрлэн дотоод болон гадаадад борлуулалт хийн ажиллаж байна. Хэтдээ дэлхийн зах зээлд гаргахаар зорьж байна.

Бид ВРN байгууллагын хөтөлбөрт 2023 оны 1-р улирлаас хамрагдан ажиллаж байгаа бөгөөд ВРN-ийн нийгэмлэгээс санал болгодог бизнес аялалд оролцон, Швейцар улсын үйлдвэрүүдээр зочлон, туршлага судлаад ирлээ.

Миний хувьд анх удаа Европын томоохон компаниудад зочлон тухайн компанийн үүсэл болон одоо хэрхэн ажиллаж байгаатай танилцсан. Маш сонирхолтой аялал байлаа. Орсон компани болгоноосоо шинэ нэг зүйлийг харж байсан. Бидний хувьд суралцах зүйл ч их санагдсан. Надад хамгийн их таалагдсан зүйлүүдээсээ та бүхэнтэй хуваалцъя.



Түвшин Тулга Трэйд  
ХХК-ийн үүсгэн  
байгуулагч  
Т.Рэнцэнханд





Бид 5 өдрийн хугацаанд 7 үйлдвэрээр зочилсон бөгөөд өөр өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани, үйлдвэрүүд байсан. Бидний зочилсон ихэнх үйлдвэрүүд нарны хураагууртай түүгээрээ цахилгаанаа шийдсэн мөн түүхий эдийн хаягдлаа дахин боловсруулж өөрсдийн хэрэгцээнд ашиглаж байгаа нь маш их таалагдсан. Мөн үйлдвэрүүд өөр өөр хотуудад байрласан нь (тухайн хотын иргэдийг ажлаар ханган) хотын бөөгнөрөл үүсэхээс сэргийлсэн санагдсан. Зарим үйлдвэр борооны усыг тосон ариун цэврийн өрөөндөө ашигладаг гээд их олон бидний мэдэх мөртөө хэрэгжүүлдэггүй зүйлүүд байдаг юм байна. Зочилсон үйлдвэр болгон өөр өөрийн онцлогтой байсан бөгөөд үнэхээр “Европ чанар” үнэртсэн сэтгэл шингэсэн сайхан үйлдвэрүүд байлаа.

Миний хувьд анх удаа Швейцар улсад очсон. Үнэхээр уул усны гайхамшиг бүрдсэн сайхан орон юм. Өмнө нь олон удаа найз нараасаа байгалийн гайхамшигийн сонсож байсан ч өөрийн нүдээр хараад үнэхээр л үзэсгэлэнт орныг нь биширсэн. Бид Zürich хотод буудалласан ба уг хот ямар ч том хотын бөөгнөрөлгүй хүмүүс нь дор бүрнээ ажлаа хийн, ажиллаж амьдрахад таатай санагдсан.

Аяллаас ирсэн даруйдаа нарны хураагуур, хаягдал түүхий эдээ дахин боловсруулахыг судалж байгаа. Мөн өөрийн брэнд дээрээ хийх маш том нэг өөрчлөлтийг олж харсан. Судалгаагаа ч хийж байгаа. Удахгүй бүгдийг хэрэгжүүлэн хийх болно.

Ийм сайхан аялал зохион байгуулсан BPN-ийн хамт олондоо маш их баярлалаа.

### Хүндэтгэсэн Т.Рэнцэнханд



**BPN нийгэмлэг нь Швейцарын SWISSCONTACT байгууллагын SEC (Senior Expert Contact) төсөлтэй хамтран ажилладаг бөгөөд уг төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээнд хамрагдсан хөтөлбөрийг оролцогчдын сэтгэгдлийг хуваалцаж байна.**

Намайг Б.Энхзул гэдэг. Манай “Алтан элч” ХХК нь “Фүүдарт” нэрийн хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргэдэг. Сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүнийхээ нэр төрөл, хөгжүүлэлтийг сайжруулах, олон улсын жишигт нийцэхүйц савлагаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Миний хувьд 2019 оноос BPN-ийн хөтөлбөрийн оролцогч болж, сургалт, зөвлөгөө болон бизнес аялалд хамрагдаж, өөрийн үйл ажиллагаа болон хувь хүний хөгжлийн түвшинд мэдэгдэхүйц хөгжил, дэвшлийг авч явна гэж дүгнэдэг. 2022 оноос BPN-ийн бизнес эрхлэгчдийн нийгэмлэгийн УЗ-ийн гишүүнээр ажиллаж нийгэмлэгийн үйл ажиллагаандаа идэвхтэй оролцож байна. Тус нийгэмлэгийн гишүүний хувьд хэд хэдэн хөтөлбөрт оролцсоноос хамгийн онцлох ажил нь энэ жилийн 7 дугаар сард мэргэжлийн технологийн экспертийг урьж, туршлага судалж, хамт ажилласныг дурдмаар байна.

Бид технологийн эксперт шаардлагатай байгаа хүсэлтээ BPN-д хүргүүлж, улмаар Швейцарын ахмад мэргэжилтнүүдийн холбоогоор дамжуулан, Швейцар улсаас мах, махан бүтээгдэхүүний технологи, үйлдвэрлэлийн олон улсын зөвлөх мэргэжилтэн Вилли Мюллер 2023 оны 7 дугаар сард гэрээний дагуу 21 хоногийн хугацаанд манай үйлдвэрт ажилласан.



Алтан элч  
ХХК-ийн үүсгэн  
байгуулагч  
**Б.Энхзул**




Юуны өмнө зөвлөх манай бүтээгдэхүүний түүхий эдийн сонголт, үйл ажиллагааны зохион байгуулалт болон үйлдвэрлэл, савлагаа, худалдаанд байршсан байдалд судалгаа дүгнэлт хийсэн. Мөн үйл ажиллагааны үе шат, дамжлага бүрд санал зөвлөгөө өгч ажилласнаас гадна зарим бүтээгдэхүүнийг амт чанарыг сайжруулах тал дээр төвлөрч ажилласан. Тэр дундаас манай Фүүдарт үйлдвэрээс гаргадаг үхрийн махан котлетыг илүү зөөлөн, шүүслэг болгох, өнгө, хадгалах тал дээр технологийн зөвлөгөө өгч, хэрэглэгчдэд амталгаа туршилт хийж, одоо зах зээлд нийлүүлсэн байна.

Мэргэжлийн талаас технологийн үйл ажиллагаанд зөвлөх Вилли Мюллер маань маш их зүйлийг зөвлөж, өөрөө гардан хийж үзүүлсэн нь бидэнд сурч, суралцах томоохон боломж байлаа. Манай зөвлөх уг мэргэжлээрээ 40 гаруй жил ажилласан асар арвин туршлагатайн дээр цаг баримтлах, ажлыг яс хийх чанар, хөгжилтэй энгийн байдал нь манай ажилтануудад үлгэр дуурайлал болсон ба мөн хувь хүн, соёлын сургалт давхар болсон гэж хэлэхэд болно.

Монголынхоо бизнес эрхлэгчдийг дэмжин, мэргэжлийн туршлагатай хүнээс өөрийн ажлын байран дээрээ суралцах боломжийг бүрдүүлсэн та бүхэндээ баярлаж байгаагаа илэрхийлье.

Баярлалаа.



“Дүүрэн фүүд” ХХК нь 2016 онд байгуулагдсан бөгөөд түргэн хоол, бэлэн бүтээгдэхүүн болох 40 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж байна.

Бид 2018 оноос 5 дахь жилдээ BPN-тэй хамтарч ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд бид технологийн зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлт тавин, ахмад зөвлөх Felix Kaufmann-тай 2023.08.17-оос 2023.09.13-ний хооронд үйлдвэр дээрээ зөвлөгөө аван ажиллаа.

Манайд ирж ажилласан зөвлөх маань чин сэтгэлээсээ тусалъя, ажлыг сайжруулъя гэсэн хандлагатай хүн байсан. Зарим асуудалд бүр бид нарын өмнөөс уурлаж байсан нь үнэхээр сайхан сэтгэгдэл үлдээсэн. Бид бүхэн түүний бүхий л мэдлэг, ур чадвараас нь суралцахыг хичээж Энэ удаагийн зөвлөх үйлчилгээг авснаар манай хамт олон байнгын суралцах ёстой, өөрсдийгөө хөгжүүлж байх ёстой гэдгийг ойлгосон. Мөн олон улсын зөвлөхүүдтэй байнгын хамтарч ажиллах нь бизнесийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтөд илүү үр дүнтэй байх юм байна гэдгээ мэдэж авлаа.



Дүүрэн Фүүд  
ХХК-ийн ерөнхий  
менежер  
**Б.Анхбаяр**





Бид зөвлөхтэй дараах асуудлууд дээр төвлөрч ажилласан ба үүнээс дурдвал:

- Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэвэр
- Технологийн процесс, хяналт
- Хэрэглэгчийн гомдол шийдвэрлэх процессыг системчлэх
- Үйлдвэрлэлийн албаны бүтэц, зохион байгуулалт, ажил үүргийн хуваарь
- Өргөтгөл, хийгдэж байгаа үйлдвэрийн зохион байгуулалт
- Шинээр баригдаж буй үйлдвэрийн төлөвлөлт

Эдгээр ярилцсан асуудал болгоны хүрээнд зохих шаардлагатай ажлууд хийгдэж, шинэчлэлт өөрчлөлтүүдийг хийж байна.

Үүнээс товч дурдвал:

- Өргөтгөж байгаа үйлдвэрийн байрны зохион байгуулалт дээр зөвлөхийн зөвлөсний дагуу өөрчлөлтийг хийсэн.
- Шинэ үйлдвэрийн байрны зураг төсөл дээр зөвлөхийн санааг тусгасан.
- Эрүүл ахуйч болон ээлжийн технологич нарийн ажил үүргийг тодорхой болгон түүний дагуу ажлаа гүйцэтгэж байна.
- Түүхий эдийн болон бэлэн бүтээгдэхүүний тодорхойлолт боловсруулан түүний дагуу хяналтаа тавьж ажиллаж байна.
- Түүхий эд хүлээн авах үеийн хяналтын заавар, хэрэглэгчийн гомдол шийдвэрлэх журмыг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Үйлдвэрлэлийн процесс дээрх бүтээгдэхүүнд учирч болзошгүй 6 хяналтын цэгийг тодорхойлон, хяналтаа тавьж байгаа.
- Lean management-ийн аргыг ашиглан үйлдвэрлэлийн процессын сайжруулалтуудаа хийж байгаа.

Felix Kaufmann зөвлөхтэй хамтарч ажиллах боломжийг бүрдүүлж өгсөн BPN -ийн хамт олонд талархсанаа илэрхийлье!

Хүндэтгэсэн,

Ерөнхий менежер Б. Анхбаяр





# БАЯРЛАГАА

## Сургалтын хуваарь

Хэрэглэгчийн менежмент

2024.01.26

Санхүүгийн менежмент

2024.02.29 - 03.01

Маркетинг

2024.03.28 - 30

Борлуулалтын өвөрмөц саналыг тодорхойлох нь (Unique Selling Proposition)

2024.04.12

Цагийн менежмент

2024.09.26 - 27

Хамт олноо удирдах

2024.10.11 - 12

Зөрчлийн менежмент

2024.11.15 - 16

Бизнесийн удирдлага

2024.11.28 - 30

